



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/60/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn Сайншанд сум 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Т.Оюунтуяа Утас: 99048991 Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншала сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хууль: dornogovi@audit.gov.mn

2023.02.24 № 46/192

тантай _____-ны № _____-т

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Т.АЗБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг ханган, мөрдсөн эсэх асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Илрүүлэлтээр Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих мэдээллүүдээс нийт 618.5 сая төгрөгийн 8 гүйлгээ, 13.7 сая төгрөгийн 2 шийдвэрийг хугацаа хоцроосон байна. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 168.9 сая төгрөгийн орлогын 2 гүйлгээ, төсөв, өмч,

01000410

хөрөнгө, мөнгө зарцуулах 38.9 сая төгрөгийн 5 шийдвэрийн мэдээлэл огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 11 харилцагчдаас 2.2 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тус байгууллагын ажилтны 0.5 сая төгрөгийн цалин хөлсийг нийгмийн даатгалд 06 кодоор буруу тайлагнасан байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор" шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүнд орно" заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж шалгаагүй, тайланг Сангийн Сайдын баталсан маягтын дагуу бараа материалын орлого, зарлага, эхний болон эцсийн үлдэгдлийн тоо ширхэг, хэмжээг тодорхой гаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3-т "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн хуулийн заалтуудыг хангаж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу "Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 7-17-ны өдрүүдэд улс орон даяар зохион байгуулсан ба уг тооллогоор 10.8 сая төгрөгийн 176 толгой малыг тус байгууллагын нэрээр бус хувь хүний нэрээр тоолуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйл "Төрийн өмчид эд хөрөнгө олж авах", 6.1.2 "үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болсон эд хөрөнгө;" 6.2-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна." заалтуудтай нийцэхгүй ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 4 зорилт, 22 арга хэмжээний хэрэгжилт 96.3 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.5 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	184,046,963.17	177,655,467.48
33	АВЛАГА	368,435.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	368,435.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	183,678,528.17	177,655,467.48
351	Түүхий эд материал	148,040,498.47	149,613,617.78
35110	Тусгай зориулалттай материал	148,040,498.47	149,613,617.78
354	Хангамжийн материал	26,568,129.70	17,226,849.70
35410	Бичиг хэргийн материал	305,250.00	74,070.00
35420	Аж ахуйн материал	13,536,489.00	7,796,289.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,937,342.00	1,460,342.00
35440	Түлш, шатах тослох материал	3,077,872.00	1,957,872.00
35450	Барилгын засварын материал	3,340,950.00	3,327,550.00
35470	Бусад хангамжийн материал	4,370,226.70	2,610,726.70
35600	Мал амьтад	9,069,900.00	10,815,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	689,159,732.32	871,172,354.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	689,159,732.32	871,172,354.21
392	Биет хөрөнгө	374,246,732.32	556,057,687.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	324,288,225.04	324,288,225.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	-58,627,421.10	-72,639,842.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	104,047,573.78	104,047,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-33,907,928.96	-46,285,857.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	284,334,476.62	274,230,687.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	-257,996,073.21	-49,973,904.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,699,787.36	29,001,443.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,394,100.22	-8,687,831.28
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,410,400.00	13,864,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,608,206.99	-11,787,207.03
393	Биет бус хөрөнгө	314,913,000.00	315,114,666.67
39301	Програм хангамж	804,248.50	220,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-804,248.50	-18,333.33
39303	Бусад биет бус хөрөнгө	314,913,000.00	314,913,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	873,206,695.49	1,048,827,821.69
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	873,206,695.49	1,048,827,821.69
51	Засгийн газрын хувь оролцоо	873,206,695.49	1,048,827,821.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	579,145,672.30	579,145,672.30
51101	Өмч: - төрийн	579,145,672.30	579,145,672.30
512	Хуримтлагдсан үр дүн	115,800,357.89	393,314,511.71
51210	Өмнөх үеийн үр дүн	115,800,357.89	217,693,385.51
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	175,621,126.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	178,260,665.30	76,367,637.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	873,206,695.49	1,048,827,821.69

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,025,648,697.65	1,222,443,552.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,643,331.65	268,968,612.62
120	Нийтлэг татварын бус орлого	59,643,331.65	268,968,612.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,643,331.65	268,968,612.62
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	289,000.00	1,410,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59,354,331.65	267,558,612.62
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	966,005,366.00	953,474,940.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	926,174,600.00	940,896,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	926,174,600.00	940,896,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,830,766.00	12,578,140.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,418,766.00	2,675,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,412,000.00	9,903,140.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,002,625,234.73	1,046,822,426.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,002,625,234.73	1,046,822,426.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	957,070,018.80	1,039,378,436.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	740,953,471.39	797,211,166.36
210101	Үндсэн цалин	535,582,639.07	670,615,791.71
210102	Нэмэгдэл	182,044,432.32	113,722,555.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,326,400.00	12,872,819.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,028,800.00	100,895,270.69
210201	Тэтгэврийн даатгал	70,390,700.00	68,619,374.63
210202	Тэтгэмжийн даатгал	7,409,500.00	8,068,774.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,927,600.00	6,455,338.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,481,900.00	1,613,837.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,819,100.00	16,137,947.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,033,813.00	22,144,994.35
210301	Гэрэл, цахилгаан	8,830,501.00	8,308,526.35
210302	Түлш, халаалт	11,239,312.00	12,751,468.00
210303	Цэвэр, бохир ус	964,000.00	1,085,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,259,733.68	27,911,813.41
210401	Бичиг хэрэг	1,173,200.00	1,332,870.00
210402	Тээвэр, шатахуун	4,617,907.00	3,837,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,502,246.68	2,325,034.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	216,000.00	204,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	750,380.00	898,200.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	19,314,208.78
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,980,578.80	25,962,081.15
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,401,958.80	22,731,581.15
210602	Тавилга	200,000.00	00.00
210604	Урсгал засвар	378,620.00	3,230,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,202,000.00	1,013,800.00
210702	Дотоод албан томилолт	2,202,000.00	1,013,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,153,053.00	8,114,890.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,167,738.00	6,728,146.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,300.00	198,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	253,672.00	176,086.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,600.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	598,500.00	484,000.00
210807	Газрын төлбөр	412,243.00	429,658.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,458,568.93	56,124,420.49
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,358,568.93	56,124,420.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,555,215.93	7,443,989.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,866,924.00	1,251,930.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,251,930.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,736,924.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,130,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	688,291.93	6,192,059.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	688,291.93	6,192,059.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	23,023,462.92	175,621,126.20
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	93,500.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	93,500.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-93,500.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	22,929,962.92	175,621,126.20

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	151,694,000.00	954,884,940.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	362,100.00	1,410,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	362,100.00	1,410,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	362,100.00	1,410,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	362,100.00	1,410,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	151,331,900.00	953,474,940.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	151,331,900.00	940,896,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	151,331,900.00	940,896,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	12,578,140.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,675,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	9,903,140.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	145,194,873.20	946,495,110.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145,194,873.20	946,495,110.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	145,194,873.20	939,051,120.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	122,006,047.00	796,842,731.36
210101	Үндсэн цалин	89,034,245.00	567,427,594.18
210102	Нэмэгдэл	29,473,902.00	180,848,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,497,900.00	19,567,137.18
210104	Урамшуулал	00.00	29,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,554,559.20	100,895,270.69
210201	Тэтгэврийн даатгал	11,731,796.87	68,619,374.63
210202	Тэтгэмжийн даатгал	1,234,854.65	8,068,774.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	987,803.15	6,455,338.00
210204	Ажилгүйдлийн даатгал	246,998.17	1,613,837.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,353,106.36	16,137,947.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,658,512.00	20,976,694.35
210301	Гэрэл, цахилгаан	1,824,280.00	8,308,526.35
210302	Түлш, халаалт	2,834,232.00	11,583,168.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,085,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	859,709.00	9,232,749.63
210401	Бичиг хэрэг	256,000.00	1,326,870.00
210402	Тээвэр, шатахуун	271,200.00	3,885,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	281,309.00	2,679,680.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	204,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	51,200.00	1,136,399.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	102,400.00	4,739,030.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	74,900.00	597,530.00
210604	Урсгал засвар	27,500.00	4,141,500.00
2107	Томилолт, зочны зардал	36,000.00	1,013,800.00
210702	Дотоод албан томилолт	36,000.00	1,013,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	977,646.00	5,350,844.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	766,646.00	3,953,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	198,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	187,086.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	211,000.00	484,000.00
210807	Газрын төлбөр	00.00	429,658.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	7,443,989.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,251,930.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,251,930.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,192,059.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,192,059.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,499,126.80	8,389,830.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	8,389,830.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	8,389,830.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	8,389,830.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	8,389,830.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-8,389,830.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	6,499,126.80	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,499,126.80	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	579,145,672.30	178,260,665.30	-13,309,679.79	744,096,657.81
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	10,000,000.00	10,000,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	579,145,672.30	178,260,665.30	-3,309,679.79	754,096,657.81
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,561,200.03	15,561,200.03
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	579,145,672.30	178,260,665.30	115,800,357.89	873,206,695.49
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	579,145,672.30	178,260,665.30	115,800,357.89	873,206,695.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	101,893,027.62	101,893,027.62
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	579,145,672.30	178,260,665.30	217,693,385.51	975,099,723.11
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	101,893,027.62	00.00	-101,893,027.62
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	175,621,126.20	175,621,126.20
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	579,145,672.30	76,367,637.68	393,314,511.71	1,048,827,821.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	940,996,800.00	936,114,740.03	4,882,059.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	940,996,800.00	936,114,740.03	4,882,059.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	939,744,800.00	934,862,810.03	4,881,989.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	801,021,800.00	796,842,731.36	4,179,068.64
210101	Үндсэн цалин	570,847,400.00	567,427,594.18	3,419,805.82
210102	Нэмэгдэл	180,848,000.00	180,848,000.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,326,400.00	19,567,137.18	759,262.82
210104	Урамшуулал	29,000,000.00	29,000,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,915,000.00	100,214,590.69	700,409.31
210201	Тэтгэврийн даатгал	68,846,300.00	68,146,299.63	700,000.37
210202	Тэтгэмжийн даатгал	8,017,200.00	8,016,791.06	408.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,413,700.00	6,413,700.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,603,400.00	1,603,400.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,034,400.00	16,034,400.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,619,900.00	20,618,264.35	1,635.65
210301	Гэрэл, цахилгаан	8,019,300.00	8,019,296.35	03.65
210302	Түлш, халаалт	11,584,800.00	11,583,168.00	1,632.00
210303	Цэвэр, бохир ус	1,015,800.00	1,015,800.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,897,100.00	7,896,279.63	820.37
210401	Бичиг хэрэг	676,400.00	676,400.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	3,885,800.00	3,885,800.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,680,500.00	2,679,680.63	819.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	204,000.00	204,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	450,400.00	450,399.00	01.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,926,300.00	2,926,300.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,359,800.00	2,359,800.00	00.00
210604	Урсгал засвар	566,500.00	566,500.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	1,013,800.00	1,013,800.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,013,800.00	1,013,800.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,350,900.00	5,350,844.00	56.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,953,100.00	3,953,100.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	198,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	187,100.00	187,086.00	14.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	484,000.00	484,000.00	00.00
210807	Газрын төлбөр	429,700.00	429,658.00	42.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1252000.00	1251930.00	70.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,252,000.00	1,251,930.00	70.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,252,000.00	1,251,930.00	70.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	940,996,800.00	936,114,740.03	4,882,059.97
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	940,896,800.00	934,704,740.03	6,192,059.97
131001	Улсын төсвөөс санхүүжих	940,896,800.00	934,704,740.03	6,192,059.97
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	100,000.00	1,410,000.00	-1,310,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	1,410,000.00	-1,310,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	66.00	66.00	00.00
620001	Удирдах ажилтан	05.00	05.00	00.00
620002	Гүйцэтгэх ажилтан	54.00	54.00	00.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	00.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		12,578,140.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		12,578,140.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		12,578,140.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		680,680.00
210201	Тэтгэврийн даатгал		473,075.00
210202	Тэтгэмжийн даатгал		51,983.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		41,638.00
210204	Ажилгүйдлийн даатгал		10,437.00
210205	Эрүүл мэндийн даатгал		103,547.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		358,430.00
210301	Гэрэл, цахилгаан		289,230.00
210303	Цэвэр, бохир ус		69,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,336,470.00
210401	Бичиг хэрэг		650,470.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		686,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		10,202,560.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		3,527,520.00
210602	Тавилга		3,100,040.00
210604	Урсгал засвар		3,575,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	12,578,140.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		12,578,140.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,675,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		9,903,140.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 111.5 сая төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 111.5 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Дахин үнэлгээний нэмэгдэл 101.3 сая төгрөгөөр илүү бүртгэснийг;
2. Тайлант хугацааны элэгдлийн зардлыг 10.2 сая төгрөгөөр дутуу байгуулсныг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 0.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 0.5 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

3.2 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих мэдээллүүдээс нийт 618.5 сая төгрөгийн 8 гүйлгээ, 13.7 сая төгрөгийн 2 шийдвэрийг хугацаа хоцроосон байна. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 168.9 сая төгрөгийн орлогын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 38.9 сая төгрөгийн 5 шийдвэрийн мэдээлэл мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

1. Мөнгөн гүйлгээний данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын тулгалтаар 11 харилцагчдаас 2.2 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай

Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”; 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим ибаримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

2. Зардлын данстай холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Тус байгууллагын ажилтны 0.5 сая төгрөгийн цалин хөлсийг нийгмийн даатгалд 06 кодоор буруу тайлагнасан байна. Энэ нь НД-ын байгууллагад үнэн зөв тайлагнаагүйгээс үүссэн зөрүүнд нөхөн шимтгэл, торгууль тавигдах үр дагавартай.

Мөн Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 “Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор” шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүнд орно” заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин хөлсийг нийгмийн даатгалын байгууллагад үнэн зөв тайлагнаж, Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж шалгаагүй, тайланг Сангийн Сайдын баталсан маягтын дагуу бараа материалын орлого, зарлага, эхний болон эцсийн үлдэгдлийн тоо ширхэг, хэмжээг тодорхой гаргаагүй байна. Энэ нь хөрөнгөнд тавих хяналт суларснаас хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, дутагдах үр дагавартай.

Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан “аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах”, “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогч сар бүр эд хариуцагчийн тайланг хянан, бараа материалын тоо ширхгийг тодорхой гаргаж, гарын үсэг болон бусад баталгаажуулалтыг ханган хариуцлагатай ажиллах.

4. Малын тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу “Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 7-17-ны өдрүүдэд улс орон даяар зохион байгуулсан ба уг тооллогоор 10.8 сая төгрөгийн 176 толгой малыг тус байгууллагын нэрээр бус хувь хүний нэрээр тоолуулсан байна. Энэ нь хөрөнгөнд тавих хяналт суларснаас хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, дутагдах үр дагавартай.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйл “Төрийн өмчид эд хөрөнгө олж авах”, 6.1.2 “үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болсон эд хөрөнгө;” 6.2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.” заалтуудтай нийцэхгүй ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хуулийн заалтуудыг мөрдөж ажиллах, байгууллагын хөрөнгөд хамаарах мал амьтныг байгууллагын нэр дээр тоолуулж, хөрөнгийг бүртгэлжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дахин үнэлгээний нэмэгдлийг 101.3 сая төгрөгөөр илүү бүртгэсэн;	1	101,319.8	0	-	1	101,319.8	1	101,319.8	0	-		
Тайлант хугацааны элэгдлийн зардлыг 10.2 сая төгрөгөөр дутуу байгуулсан;	1	10,180.8	0	-	1	10,180.8	1	10,180.8	0	-		
Дүн	2	111,500.6	-	-	2	111,500.6	2	111,500.6	0	-		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс			
									Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тулгалтаар 11 харилцагчдаас 2.2 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна.	1				-	-	1					
Ажилтны 7-р сарын цалинг НД-д 06 кодоор буруу тайлагнасан байна.	1	523.9			-	-	1	523.9				
Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж шалгаагүй, тайланг Сангийн Сайдын баталсан маягтын дагуу бараа материалын орлого, зарлага, эхний болон эцсийн үлдэгдлийн тоо ширхэг, хэмжээг тодорхой гаргаагүй байна.	1						1					

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу “Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллогыг 2022 оны арванхоёрдугаар сарын 7-17-ны өдөр улс орон даяар зохион байгуулсан ба уг тооллогоор 10.8 сая төгрөгийн 176 толгой малыг тус байгууллагын нэрээр бус хувь хүний нэрээр тоолуулсан байна.	1					1					
Дүн	4	523.9			-	-	4	523.9			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих мэдээллүүдээс нийт 618.5 сая төгрөгийн 8 гүйлгээ, 13.7 сая төгрөгийн 2 шийдвэрийг хугацаа хоцроосон байна. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 168.9 сая төгрөгийн орлогын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 38.9 сая төгрөгийн 5 шийдвэрийн мэдээлэл огт мэдээлээгүй байна.	1		-	-	1	-		
Дүн	1		-	-	1	-		

